

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН НООГДУУЛСАН ТОРГУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД АНХААРЧ АЖИЛЛААГҮЙГЭЭС 2023-2024 ОНД 442.8 САЯ
ТӨГРӨГИЙН ОРЛОГЫГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2025/27-20-ШТА-ГА

Дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Аудитор Б.Ариунтуяа
Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

Аудитор Ц.Чагнаадорж
Утас: 99387994 Цахим хаяг: chagnaadorj.ts@audit.gov.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
khuvsgul.audit.mn/state/16 цахим хуудаснаас авна уу.

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
А.Эрдэнэбаатар
Аудитын менежер
Б.Тэгшдэлгэр
Ахлах аудитор
Б.Давааням
Аудитор
Г.Ичинхорлоо
Б.Ариунтуяа
Ц.Чагнаадорж

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах,
асууж лавлах зүйл
гарвал 70384043
дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум
Аймгийн ЗДТГ-ын “А”
корпус 3 давхар

Цахим хаяг:
audit.mn/?page_id=579

**2025 оны 07 дугаар
сар**

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

БҮЛЭГ 1. Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, эрх бүхий байгууллагуудын саналыг үндэслэхгүйгээр төлөвлөсөн байна.

- А.1. Хүү, торгуулийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй байна.
- А.2. Торгуулийн орлогыг эрх бүхий байгууллагуудын саналыг харгалзахгүйгээр өмнөх оны гүйцэтгэлээс бууруулан төлөвлөж байна.
- А.3. Хүү, торгуулийн орлогыг Төсвийн тухай хуульд заасны дагуу татварын бус орлогын эх үүсвэрээр тооцон төлөвлөж тайлагнасан байна.

БҮЛЭГ 2. Эрх бүхий албан тушаалтны ноогдуулсан торгуулийн хэрэгжилтийг нэгдсэн байдлаар хянах тогтолцоо бүрдээгүйгээс 2023-2024 онд орон нутгийн төсөвт 442.8 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

- Б.1. Орон нутгийн төсөвт 2023-2024 онд 994.1 сая төгрөгийн хүүгийн орлого, 442.8 сая төгрөгийн торгуулийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.
- Б.2. Торгуулийн орлогоос төсвийн эх үүсвэр болгон хуваарилах зардлыг 2023 онд 192.9 сая төгрөг, 2024 онд 312.3 сая төгрөгөөр тус тус дутуу хуваарилсан байна.

БҮЛЭГ 3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

- В.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд хуваарилсан 669.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч үр дүнг тооцоогүй байна.
- В.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг эрх бүхий байгууллагуудын санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэн шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн байна.

БҮЛЭГ 4. Хүү, торгуулийн орлогын нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг нэвтрүүлээгүй, ноогдуулсан торгуулийн хэрэгжилтэд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх чиг үүргийн байгууллагыг хуулиар тодорхойлоогүй байна

- Г.1. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлээгүй, мэдээллийн сан бий болоогүй байна.
- Г.2 Эрх бүхий байгууллагуудаас ногдуулсан торгуулийн хэрэгжилтэд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх чиг үүргийн байгууллагыг хуулиар тодорхойлоогүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Хавсралтууд

Холбогдох байгууллагын санал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЖДҮ	Жижиг Дунд Үйлдвэрлэл
ХӨА	Хөвсгөл Аймаг
ШТА	Шууд Тайлагнах Ажил



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/21

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Цагдаагийн газар, Байгаль орчны газар, Татварын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хөвсгөл аймгийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Стандарт хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), Цагдаагийн газрын дарга Цагдаагийн хурандаа (Д.Мөнхжаргал), Татварын газрын дарга (Ч.Хуншагай), Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Лхагвадорж), Хөвсгөл аймгийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн), Стандарт хэмжил зүйн газрын дарга (Д.Батцоож), Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр), Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга (А.Догсмоо) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор (Б.Давааням)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



Аудитын нэр, код	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт гүйцэтгэлийн аудит /ХӨА-2025/27-20-ШТА-ГА/
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрх.
Аудитын зорилго	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ
Зорилт	• Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх; • Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх; • Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх; • Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
Хамарсан хүрээ	Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын 2023-2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн баримт материал, тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулан гүйцэтгэсэн. Аудитад нийт 30 байгууллага, 275 албан тушаалтны 2023-2024 оны баримт материалыг хамруулан судалгааг авч нэгтгэсэн болно.
Аудитын арга зүй	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторовын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгааны арга зүйг ашигласан
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	• Төсвийн тухай хууль; • Татварын багц хуулиуд; • Гаалийн ерөнхий хууль; • Засгийн газрын тусгай сангийн тухай хууль; • Автозамын тухай хууль; • Зөрчлийн тухай хууль; • Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль; • Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль; • Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль; • Байгаль орчныг хамгаалах тухай хууль; • Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль; • Төрийн аудитын тухай хууль;

	- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; - Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”; - Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”; - Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”; - Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”; - Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”; - Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”; - Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.
Багийн бүрэлдэхүүн	Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Давааням, аудитор Ган.Ичинхорлоо, Б.Ариунтуяа, Ц.Чагнаадорж нар гүйцэтгэсэн

Үндсэн мэдээлэл:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт “... хүү, торгуулийн орлого” нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч “хүү, торгуулийн орлого” гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнаж байна.

Төсвийн орлогын ангиллыг 2023, 2024 оноор харьцуулан харуулбал:

Орон нутгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт

Хүснэгт №-1

/Сая төгрөгөөр/

№	Аймаг, сум	Хүүгийн орлогын гүйцэтгэл		Торгуулийн орлогын гүйцэтгэл		Нийт	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
	Аймаг	136.80	191.33	635.54	741.29	772.3	932.6
1	Алаг-Эрдэнэ	-	-	18.75	34.11	18.8	34.1
2	Арбулаг	-	-	8.63	5.68	8.6	5.7
3	Баянзүрх	-	-	7.67	5.83	7.7	5.8
4	Бүрэнтогтох	-	-	7.96	5.87	8.0	5.9
5	Галт	-	-	2.26	2.15	2.3	2.2
6	Жаргалант	-	-	7.19	4.32	7.2	4.3
7	Их-Уул	-	-	23.46	24.03	23.5	24.0
8	Рашаант	-	-	11.32	3.24	11.3	3.2
9	Рэнчинлхүмбэ	-	-	11.00	5.07	11.0	5.1
10	Тариалан	-	-	49.85	34.86	49.9	34.9
11	Тосонцэнгэл	-	-	24.06	33.49	24.1	33.5
12	Төмөрбулаг	-	-	5.61	8.06	5.6	8.1
13	Түнэл	-	-	7.34	8.16	7.3	8.2
14	Улаан-Уул	-	-	11.83	7.52	11.8	7.5
15	Ханх	-	-	2.15	1.86	2.2	1.9

16	Цагаан-Уул	-	-	7.77	7.50	7.8	7.5
17	Цагаан-үүр	-	-	4.49	6.67	4.5	6.7
18	Цэцэрлэг	-	-	6.20	4.40	6.2	4.4
19	Чандмань-Өндөр	-	-	5.54	4.33	5.5	4.3
20	Шинэ-Идэр	-	-	10.19	5.30	10.2	5.3
21	Хатгал	-	-	32.31	39.03	32.3	39.0
22	Мөрөн	-	-	552.09	736.41	552.1	736.4
23	Эрдэнэбулган	-	-	14.20	14.65	14.2	14.6
24	Цагааннуур	-	-	13.91	2.80	13.9	2.8
НИЙТ		136.8	191.3	1,481.3	1,746.6	1,618.1	1,938.0

Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн мэдээллээр орон нутгийн хэмжээнд 2023 онд 1,618.1 сая төгрөг, 2024 онд 1,938.0 сая төгрөгийн хүү, торгуулийн орлого бүрдүүлсэн байна.

Торгууль ногдуулах процессын зураглал



БҮЛЭГ-1

Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, эрх бүхий байгууллагуудын саналыг үндэслэхгүйгээр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т зааснаар хүү, торгуулийн орлого нь төсвийн орлогыг бүрдүүлдэг татварын бус орлого гэж тодорхойлсон байна.

Орон нутгийн 2023-2024 оны төсөвт хүү, торгуулийн орлогыг анх 3,209.6 сая төгрөгөөр тооцон, 1,745.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 4,955.4 сая төгрөгөөр баталсан байна.

Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө.

Хүснэгт №-2

/Сая төгрөгөөр/

Орлого	2023 он			2024 он			Нийт		
	Төсвийн санал	Төлөвлөгөө	Зөрүү	Төсвийн санал	Төлөвлөгөө	Зөрүү	Төсвийн санал	Төлөвлөгөө	Зөрүү
Хүү	836.8	836.8	0	485.4	485.4	0	1,322.2	1,322.2	-
Торгууль	883.0	2,128.0	(1,245.0)	1,004.4	1,505.2	(500.8)	1,887.4	3,633.2	(1,745.8)
Дүн	1,719.8	2,964.8	(1,245.0)	1,489.8	1,990.6	(500.8)	3,209.6	4,955.4	(1,745.8)

Орон нутгийн төсөвт хүүгийн орлогын төлөвлөгөөг “Хөвсгөл Эрчим хүч” ХХК, “Хөвсгөл ус суваг” ХХК-д Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэлд тооцогдох хүүгийн төлбөрийг тооцож төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд орон нутгийн дансанд хүүгийн орлого төвлөрүүлэгч 3, торгуулийн орлого төвлөрүүлэгч 12 байгууллага байна. Эдгээр байгууллагууд нь хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөнд санал ирүүлдэггүй бөгөөд аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс нь орлогыг төлөвлөж байна.

А.1 Хүү, торгуулийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2023-2024 онуудад хүүгийн орлогыг дараах байдлаар төлөвлөсөн байна. Хүүгийн орлогын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-3

/Сая төгрөгөөр/

Зээлдэгч	2023 он	2024 он
Хөвсгөл Эрчим хүч ХХК	143.2	191.7
Хөвсгөл Ус суваг ХХК	693.6	293.7
Дүн	836.8	485.4

Төлөвлөж байгаа хүүгийн орлого нь шинж чанарын хувьд орон нутгийн орлого биш бөгөөд дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүд төлөх төлбөрийг хүүгийн орлогоор төлөвлөсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4¹, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2² дахь заалттай нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 08 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих орон нутгийн тусгай сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан Хаан банктай “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сангийн зээл олгох талаар хамтран ажиллах гэрээ”-г шинэчлэн байгуулсан байна. Тус гэрээний 3 дугаар хэсгийн 3.3-т сангаас олгосон зээлийн эх үүсвэрийн санхүүжилтэд жилийн 2 хувийн хүү тооцож, улирал бүр олгохоор тусгасан байна.

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь 2023.12.20-ны өдөр Хаан банктай байгуулсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих орон нутгийн тусгай сангийн зээл олгох талаар хамтран ажиллах гэрээ”-ний 3.3³-т заасан хүүгийн төлбөр болох 9.6 сая төгрөгийг төлөөгүй байсныг аудитын хугацаанд Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангийн 100170051402 тоот дансанд төвлөрүүлж зөрчлийг арилгасан.

Зээлийн хүүгийн орлогын төлөвлөгөөнд өр төлбөрийг хүүгийн орлогоор төлөвлөсөн, ЖДҮ сангийн харилцах дансны үлдэгдэлд тооцогдсон хүүгийн төлбөрийг төлөвлөгөөнд тусгаагүй нь бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүйг харуулж байна.

¹ үнэн зөв байх

² орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого

³ “В тал нь гэрээний 3.2-т заасан санхүүжилтэд жилийн 2% -ийн хүү тооцон олгох ба”

Торгуулийн орлогын төлөвлөлт:

Орон нутгийн төсөвт торгуулийн орлогыг 2023 онд 1,291.2 сая төгрөг, 2024 онд 1,505.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2023 онд 1,481.3 сая төгрөг, 2024 онд 1,746.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл.

Хүснэгт №-4

/Сая төгрөгөөр/

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2020	1,003.6	990.1	13.5
2021	1,069.7	1,244.4	(174.7)
2022	936.4	1,453.7	(517.3)
2023	1,291.2	1,481.3	(190.1)
2024	1,505.2	1,746.7	(241.5)

Хүснэгтээс харахад торгуулийн орлого нь 2020-2024 онд жил бүр төлөвлөсөн дүнгээс 174.1-241.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Торгуулийн орлого нь төсвийн эх үүсвэрийг жил бүр 1.5-1.7 тэрбум

төгрөгөөр нэмэгдүүлж байгаа нь тухайн орлогыг төлөвлөхгүй бол төсвийн бусад эх үүсвэрийг энэ хэмжээгээр нэмэгдүүлэх, эсвэл зардлыг бууруулан төлөвлөх шаардлага үүсэж байна.

Аудитын нэгдсэн судалгаанаас зөрчлийн тоо болон ноогдуулсан торгуулийн хэмжээг харуулбал:

Хүснэгт №-5

/Сая төгрөгөөр/

2023 он		2024 он	
Зөрчлийн тоо	Ноогдуулсан торгуулийн дүн	Зөрчлийн тоо	Ноогдуулсан торгуулийн дүн
31,094	1,610.3	23,887	1,249.9

Хүснэгтээс харахад жил бүр 23,887-31,094 зөрчилд 1,249.9-1,610.3 сая төгрөгийн торгууль ноогдуулж байгаа нь тус орлогыг орон нутгийн төсвийн эх үүсвэр болгон урьдчилан тооцож,

төлөвлөх нь зөрчил илрүүлэх, хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хариуцлагыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл тул торгуулийн орлогыг төлөвлөх зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

А.2. Торгуулийн орлогыг эрх бүхий байгууллагуудын саналыг харгалзахгүйгээр өмнөх оны гүйцэтгэлээс бууруулан төлөвлөж байна.

Торгуулийн орлогыг 2022-2025 онуудад дараах байдлаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №-6

/Сая төгрөгөөр/

Хяналтын байгууллагууд	2022 он		2023 он		2024 он		2025 оны санал
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө
Татварын хяналт	230.0	447.9	171.2	209.9	185.8	406.2	82.5
Шүүх	-	2.0	-	2.9			-
Цагдаа. Үүнээс:	596.4	877.9	1,000.0	1,133.6	1,199.4	1,197.2	510.5
Авто торгууль	477.1	702.3	800.0	907.1	720.0	957.8	459.5
Салбарын хяналтын байцаагч	50.0	21.6	40.0	44.0	40.0	65.2	21.5
Байгаль орчин байцаагч	40.0	39.5	40.0	47.9	40.0	41.1	19.6
Бусад	20.0	64.8	40.0	43.3	40.0	36.9	11.4
Нийт дүн	936.4	1,453.7	1,291.2	1,481.6	1,505.2	1,746.6	645.5

Хүснэгтээс харахад торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 2022 онд 308.0 сая төгрөгөөр, 2023 онд 162.5 сая төгрөгөөр, 2025 оны төсвийн саналыг 645.5 сая төгрөгөөр хүргүүлсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс 1,101.2 сая төгрөгөөр буюу 3 дахин бууруулж төлөвлөсөн нь торгуулийн орлогыг гүйцэтгэл болон суурь судалгаанд үндэслэн төлөвлөөгүйг харуулж байна. Энэ нь

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3⁴-т заасантай нийцэхгүй байна.

Хүүгийн орлогыг төлөвлөхдөө гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцон төлөвлөсөн байна. Үүнд:

- Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2024 оны байдлаар “Хөвсгөл Эрчим хүч” ХХК 758.5 сая төгрөг, “Хөвсгөл ус суваг” ХХК 12,617.5 сая төгрөг нийт 13,376.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл байна.
- Дээрх гэрээний төлбөрийн үлдэгдлээс тооцогдох хүүг валютын ханшийн хэлбэлзлийг харгалзан 2023 онд 836.8 сая төгрөг, 2024 онд 485.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

Эрх бүхий албан хаагчдын ноогдуулсан торгуулийн орлого төвлөрүүлэлт нь харилцан адилгүй зарим байгууллагуудын хувьд орон нутгийн төсвийн дансанд зарим нь улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байгууллагуудыг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Орлого төвлөрүүлэлт:

Хүснэгт №-7

/Сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн		
	2023 он	2024 он	Нийт
Эрүүл мэндийн газар	-	3.5	3.5
Монгол банк	1.0		1.0
ТЕГ-ын Хөвсгөл аймаг дахь хэлтэс	0.5	0.2	0.7
Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хороо	0.5	0.2	0.7
Хөвсгөл аймгийн ХХҮГ	1.7	14.8	16.5
Мал эмнэлгийн газар	0.2	0.9	1.1
Хөвсгөл Автотээврийн төв	2.5	1.8	4.3
Нийгмийн даатгалын газар	-	0.1	0.1
Байгаль орчны газар	0.3		0.3
Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	3.1	6.1	9.2
Дүн	9.7	27.5	37.2

Хүснэгтээс харахад 37.2 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7⁵, 23.7.2⁶ дахь заалттай нийцэхгүй байна.

Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого төвлөрүүлэгч байгууллагуудын санал, төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл, тооцоо судалгаа, эх үүсвэрийг бодитой тодорхойлоогүй, хүүгийн орлогод дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүд төлөх төлбөрийг тусгасан, ЖДҮ-ийг дэмжих сангийн харилцах дансны үлдэгдэлд бодогдох хүүг төлөвлөөгүй, зэргээс харахад орлогын эх үүсвэрийг үнэн зөв тодорхойлоогүй байна.

А.3. Хүү, торгуулийн орлогыг Төсвийн тухай хуульд заасны дагуу татварын бус орлогын эх үүсвэрээр тооцон төлөвлөж тайлагнасан байна.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн нийцлийг хянахад дараах байдлаар зарим зүйл заалтууд нь хоорондоо зөрчилдөж байна. Үүнд:

Хүснэгт №-8

Зөрчилдөж байгаа хуулийн заалтууд	
Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.“Доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсэж татвар төлөгч татварын өрийг төлөх боломжгүй болох нь тогтоогдсон бол татвар төлөгчийн бичгээр, эсхүл	Зөрчлийн тухай хуулийн 2.3.“татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд тушаах”

⁴ “Суурь төсвийн саналд үндэслэн төсвийн төсөл боловсруулах”

⁵ Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ

⁶ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”

цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн харьяа татварын алба татвар төлөх хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар сунгаж хөнгөлөлт үзүүлж болно”	
Татварын ерөнхий хуулийн 53.2.Татвар төлөгч энэ хуулийн 53.1-д заасан хөнгөлөлтийн хугацаанд татварын өрийг төлөх боломжгүй хүндэтгэн үзэх нөхцөл үүссэн тохиолдолд татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн харьяалах татварын алба хугацааг дахин сунгаж болно. Сунгах хугацаа нь анхны хөнгөлөлтийг оруулан нийт 2 жилээс илүүгүй байна	Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйл."Татварын хууль зөрчих"-ийн 1."Татварыг хуулиар тогтоосон хугацаанд нь төлөөгүй бол хүн, хуулийн этгээдийг хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй татварын 0.1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”
Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд.. ...Зөрчлийн тухай хуулийн... ..14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл... ..заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.	Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 2.5.4. нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;
ЗГ-ын 2021 оны 135 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам"-ын 2.4-т "Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага нь шийтгэлийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна" гэж заасан байна.	Харин Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал, 1.8 дугаар зүйлийн 6-д "Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ:" гэж заасан байгаа нь тодорхой бус ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дугаар хэсэг: Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ: 6.52. хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 10.12, 10.13, 10.14 дүгээр зүйл, 10.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг , 10.16, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;	Харин Зөрчлийн тухай хуулийн 10.15 дахь заалт нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчсөн зөрчилд тухайн эрх бүхий байцаагч шийтгэл ноогдуулах үйл ажиллагааг зааж өгсөн байна.

Хүснэгтээс дээрх хуулийн заалтууд нь хоорондоо уялдаагүй, зарим заалтууд нь харилцан үгүйсгэсэн хэлбэртэй байгааг харж болохоор байна.

Жишээлбэл: **Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч** нь Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.52 дахь заалтын дагуу хяналт хэрэгжүүлж, шийтгэл ноогдуулахын тулд заавал **хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын байцаагчийн** хамт талбарт ажиллах шаардлага үүсэж байгааг хүснэгтийн хамгийн сүүлийн мөрөнд харуулсан байна.

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж буй дараах хууль эрх зүйн заалтууд байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуульд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих аргачлалыг тусгайлан зааж өгөөгүй байна.

2. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 4.2.1⁷, 4.2.2⁸-т гэж заасан боловч татварын бус орлого буюу торгуулийн орлогын төлөвлөлтийн талаар тодорхой тусгасан зүйл заалт байхгүй байна.
3. “Татварын ерөнхий хууль”-д татварын орлогыг хэрхэн бүрдүүлэх, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх зэрэг үйл ажиллагааг зохицуулдаг. Гэвч энэ хуульд торгуулийн орлогыг хэрхэн бүрдүүлэх хяналт тавих талаар тодорхой заалт байхгүй.
4. “Зөрчлийн тухай хууль”-д зааснаар, зөрчил үйлдсэн этгээдэд торгууль ногдуулах, албадлагын арга хэмжээ авах зэрэг зохицуулалтууд байдаг. Гэвч энэ хуульд торгуулийн орлогыг хэрхэн бүрдүүлэх, түүнийг төсөвт хэрхэн төвлөрүүлэх талаар тодорхой зааварчилгаа дутмаг байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2023 онд 1,610.3 сая төгрөг, 2024 онд 1,249.9 сая төгрөгийн торгуулийг ногдуулсан байна. Ногдуулсан торгуулийн 74.7-78.0 хувийг цагдаагийн газрын торгууль эзэлж байна.

Цагдаагийн газрын 2023-2024 онд ногдуулсан торгуулийг зөрчлийн ангиллаар нь 100.0 сая төгрөгөөс дээш гарсан торгуулийн мэдээллийг түүвэрлэн авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- 14.7.1 1. “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” дахь заалтаар 236.6 сая төгрөг,
- 14.7.20 Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар тээврийн хэрэгслийн жолооч, эсхүл зорчигч хамгаалах бүс хэрэглээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно дахь заалтаар 220.1 сая төгрөг
- 14.7.3.1 3.2. “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” дахь заалтаар 332 сая төгрөг,
- 14.7.5.1 5.1. “согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон” дахь заалтаар 200.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Цагдаагийн байгууллагын ногдуулсан торгуулийн зөрчлийн үндэслэлийг үзэхэд тухайн зөрчилд ногдуулсан торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нийцэж байна гэж үзлээ.

Мал эмнэлгийн газрын эрх бүхий албан тушаалтантай уулзалт хийхэд Зөрчлийн тухай хуулийн дараах заалтуудаар торгуулийн арга хэмжээ авахад торгуулийн дүнг малын тоо толгойтой уялдуулахгүйгээр нийтлэг байдлаар тогтоосон нь малчдын хариуцлагыг сулруулж, зөрчлийг арилгахгүй, торгуулиа төлөөд өнгөрөөх хандлагатай байдгийг илэрхийлсэн. Үүнд:

- 13.9 дүгээр зүйлийн 2. “Мал эмнэлгийн холбогдолтой журам, заавар зөрчсөний улмаас өвчин тархаах, малын гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдах, мал, амьтныг тарчлаан зовоох нөхцөл байдал үүссэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.
- 13.9 дүгээр зүйлийн 3. “Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь дархлаажуулалт хийх, сорьц авах үед болон мал, амьтанд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, тодорхой бус шалтгаанаар хорогдсон тохиолдолд авч хэрэгжүүлэхээр хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж

⁷ “орон нутгийн төсвийн нийт орлогыг орон нутгийн төсвийн суурь орлого болон хуулиар эрх олгосны дагуу тухайн орон нутагт татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон орлогын нийлбэрээр;”

⁸ “орон нутгийн төсвийн суурь орлогыг тухайн шатны төсөвт орох Улсын Их Хурлаас тогтоосон татварын доод хувь, хэмжээгээр тооцсон татварын болон татварын бус орлогын нийлбэрээр;”

хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан байна.

Малчид нь дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй тохиолдолд үр дагавар, үзүүлэх нөлөө нь бусдын мал амьтанд халдах, өргөн тархах эрсдэлийг дагуулж байна.

Аудитаар авсан нэгдсэн судалгааны үр дүнгээс харахад иргэн, хуулийн этгээдэд ногдуулсан торгууль, шийтгэлийн эрх зүйн үндэслэл нь Зөрчлийн тухай хуулийн заалтууд байна. Зөрчлийн тухай хуульд иргэн, хуулийн этгээдийг үйлдсэн зөрчилд нь үндэслэн торгууль ногдуулахаар зохицуулсан бөгөөд зөрчлийн хэлбэрээс нь шалтгаалан зарим иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх заалт байхгүй бүх нийтэд тэгш үйлчлэх зохицуулалттай байна.

Торгуулийн орлого бүрдүүлэлтэд дараах тодорхойгүй асуудлууд нөлөөлж байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд торгуулийн орлогын бүрдүүлэлтийг нарийвчлан тусгах, хяналт тавьж хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллага албан тушаалтныг тодорхойлоогүй.
- Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд торгуулийн орлогыг төлөвлөх, ямар арга хэмжээнд зарцуулах талаар тодорхой тусгаагүй.
- Хүү торгуулийн орлогыг хуваарилах аргачлал байхгүй

Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, бүртгэх бүх шатанд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй ба одоогийн байдлаар торгууль ногдуулсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан хэрэгжилтийг хариуцан хангуулж байна.

Зөрчлийн тухай хуульд иргэний өмчийн халдашгүй байдалд нөлөөлөх дараах заалтууд байна. Үүнд: Зөрчлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйл. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах

- Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, зэвсэг, хэрэгслийг **хураана**.
- Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний **амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй**.

Дээрх заалтууд нь хууль зөрчсөн иргэдийн амьжиргааны түвшнээс нь хамааруулан хөрөнгийг нь хураах, зарим нөхцөлд хураахгүй байх хуулийг 2 өөр хэлбэрээр хэрэглэх нөхцөлийг үүсгэсэн бөгөөд иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдөж байна.

Хүү торгуулийн орлогыг төлөвлөхдөө бодит гүйцэтгэл, суурь судалгаанд үндэслээгүй, эрх бүхий байгууллагуудын санал, оролцоог харгалзаагүй, эх үүсвэрийг үнэн зөв тодорхойлоогүй байна.

БҮЛЭГ-2

Эрх бүхий албан тушаалтан ноогдуулсан торгуулийн хэрэгжилтэд анхаарч ажиллаагүйгээс 2023-2024 онд 442.8 сая төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын **Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн** дагуу торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлэх чиг үүргийг салбар тус бүрийн хуулиар тодорхойлж өгсөн байна. Жишээлбэл:

- Гаалийн тухай хуулийн 273 дугаар зүйлд гаалийн улсын байцаагчийг тодорхойлсон бөгөөд 274 дүгээр зүйлд хэрэгжүүлэх эрх, үүргийг тусгаж өгсөн байна.
- Авто тээврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д авто тээврийн хяналтын улсын байцаагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон байна.

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлд байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлсон байна.
- Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.30-д “татварын улсын байцаагч”-ийг тодорхойлсон бөгөөд холбогдох багц хуулиудад хэрэгжүүлэх чиг үүргийн талаар тусгаж өгсөн байна. /гэх мэт.../

Орон нутгийн төсөвт торгуулийн орлого төвлөрүүлдэг аймгийн төсвийн байгууллагуудын болон 24 сумын нийт 51 данс байна. Эдгээр дансанд төвлөрсөн торгуулийн орлогыг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд тусгаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэн тайлагнаж байна. Дансны ерөнхий ангиллыг харуулбал:

- 952 – Татварын торгууль
- 982 – Санхүү хяналт, дотоод аудитын газар
- 988 – Цагдаагийн газар, бусад

Хүү, торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг орлогын нэг төрөл бөгөөд эдгээр орлогыг хуваарилах чиг үүрэг нь аймгийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч, сумдын хувьд төсвийн төвлөрүүлэн захирагчид байна.

Торгуулийн орлогыг дараах хууль эрх зүйн хүрээнд хуваарилахаар хуульчилсан байна. Үүнд:

- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д “Зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд,
- 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ гэж заасан байна.

Б.1 Улс, орон нутгийн төсөвт 2023-2024 онд 994.1 сая төгрөгийн хүүгийн орлого, 442.8 сая төгрөгийн торгуулийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2023-2024 онд ноогдуулсан хүү, торгуулийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №-9

/Сая төгрөгөөр/

№	Он	Хүүгийн орлого				Торгуулийн орлого			
		Ноогдуулсан	Төвлөрсөн	Илүү	Дутуу	Ноогдуулсан	Төвлөрсөн	Илүү	Дутуу
1	2023 он	903.8	203.8		700.0	1,610.3	1,399.5	1.3	211.9
2	2024 он	570.3	276.8	0.6	294.1	1,249.9	1,025.0	6.0	230.9
Нийт дүн		1,474.1	480.6	0.6	994.1	2,860.2	2,424.5	7.3	442.8

/Эх сурвалж: “Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт” гүйцэтгэлийн аудитын нэгдсэн судалгаа/

Хүснэгтээс харахад **хүүгийн** орлогын гүйцэтгэл 2023 онд 22.5%, 2024 онд 48.5% байгаа нь Хөвсгөл ус суваг ХХК жил дараалан алдагдалтай ажиллаж, зээлийн хүүгийн төлбөрийг бүрэн төлөх боломжгүй болсонтой холбоотой байна.

Орон нутгийн өмчит компаниуд нь санхүү, төсвийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлж, компанийг ашигтай ажиллуулаагүйгээс 994.1 сая төгрөгийн өр төлбөргүй ажиллах боломжийг алдсан байна.

Торгуулийн биелэлтийн хувийг тооцож үзвэл 2023 онд 86.9%, 2024 онд 82.0%-ийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн хувь хангалттай хэмжээнд байгаа боловч дутуу төвлөрүүлсэн 442.8 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлсэн 37.2 сая төгрөг, нийт 480.0 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлж чадаагүй байна.

Торгуулийн орлого нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал болон замын сангийн хөрөнгийн эх үүсвэр болдог тул тухайн чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой хөрөнгө оруулалтаас жишээ татан 480.0 сая төгрөгийн дутуу төвлөрсөн орлогын хувьд алдагдсан боломжийг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

- Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөөг 0.8 хувиар давуулан биелүүлэх боломжийг алдсан байна.
- Аймгийн төвд 150 ширхэг хяналтын камер нэмж суурилуулах хөрөнгө оруулалтыг хийж болох байсан. /2022 оноос эхлэн хэрэгжиж байгаа “Ногоон бүс камержуулалт” хөтөлбөрт зарцуулсан төсвөөс дундажлан тооцоолсон/
- Дээрх хэмжээний орлогоор аймгийн төвд 0.5 км хатуу хучилттай зам барих боломжтой байсан.

Аудитад хамрагдагч байгууллагуудаас эрх бүхий албан тушаалтны судалгааг авахад Хөвсгөл аймгийн хэмжээнд нийт **275** эрх бүхий албан тушаалтан торгох шийтгэл ноогдуулж байна. Эрх бүхий албан тушаалтны судалгааг хавсралт №1-ээс харна уу.

Судалгаанаас харахад Мал эмнэлгийн газрын 3 байцаагч, Байгаль орчны газрын 2 байцаагч улсын байцаагчийн эрхгүй байна. Байцаагчийн эрх авах хүсэлтээ харьяа яамдад хүргүүлсэн, шийдвэр гарахыг хүлээх шатанд байна. Тухайн байцаагчийн илрүүлсэн зөрчлийн хэргийг аймгийн эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлж байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд газар зохион байгуулалттай холбоотой зөрчилд торгох шийтгэл ноогдуулах газар, геодези, зураг зүйн хяналтын 1 улсын байцаагч ажиллаж байна. Хөвсгөл аймгийн хэмжээнд газар олголт, ашиглалттай холбоотой зөрчил, маргаан их байдаг боловч хяналт тавих, зөрчил таслан зогсоох эрх бүхий албан тушаалтны хүний нөөц дутмаг байгаа нь зөрчлийн илрүүлэлт, давтамж буурахгүй байгаа нэг шалтгаан болж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хүү, торгуулийн орлогыг дараах байдлаар тайлагнасан байна.

Хүснэгт №-11

/Сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
12	Татварын бус орлого	2,128.0	1,618.1	509.9	1,990.6	1,937.9	52.7
120002	Хүүгийн орлого	836.8	136.8	700.0	485.4	191.3	294.1
120003	Торгуулийн орлого	1,291.2	1,481.3	(190.1)	1,505.2	1,746.6	(241.6)

Хүснэгтээс үзэхэд хүүгийн орлогын төлөвлөгөө 2023 онд 700.0 сая төгрөгөөр, 2024 онд 294.1 сая төгрөгөөр тасарсан байна. /Шалтгааныг бүлэг Б.1 дэх хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан/

Хүүгийн орлогыг Хөвсгөл эрчим хүч ХХК, Хөвсгөл ус суваг ХХК-уудын төлсөн дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүгийн орлогын гүйцэтгэлээр үнэн зөв тайлагнасан байна.

Торгуулийн орлогын дансны хуулгаар орсон орлогыг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлагнасан орлоготой харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №-12

/Сая төгрөгөөр/


2023 он			2024 он		
Нийт дансны хуулгаар орлого	Тайлангаарх торгуулийн орлого	Зөрүү	Нийт дансны хуулгаар орлого	Тайлангаарх торгуулийн орлого	Зөрүү
1,474.0	1,481.3	(7.3)	1,759.4	1,746.6	12.7

Хүснэгтээс харахад 2023 онд дансны хуулгаар нийт 1,474.0 сая төгрөгийн орлого орж, 7.3 сая төгрөгийн гүйлгээг залруулж, 1,481.3 сая төгрөгөөр, 2024 онд дансны хуулгаар нийт 1,759.4 сая төгрөгийн орлого орж, 12.7 сая төгрөгийн залруулж, 1,746.6 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч зөв дүнгээр тайлагнасан байна.

Торгуулийн орлого төвлөрүүлэх дансыг байгууллагаар ангилсан байгаа боловч иргэдээс ямар зөрчлийн торгуулийг төлж байгаа нь тодорхой бус, гүйлгээний утга дээр овог нэр, регистрийн дугаар бичиж төлсөн байна. Энэ нь торгуулийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг

байгууллага бүрээр гаргах боломжгүй, хяналт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байгаа тул зөвлөмж хүргүүлсэн.

Орон нутгийн төсвийн нийт орлого болон татварын бус орлогод эзлэх хувийн жингээр бусад орлогын эх үүсвэрт нөлөөлж буй нөлөөллийн талаар:



Хүү, торгуулийн орлого нь нийт орлогын 1.6-2.2 хувийг, нийтлэг татварын бус орлогын 31 хувийг эзэлж байна. Үүнийг графикаар харуулбал:

Хүү, торгуулийн орлого нь нийт орлогын гүйцэтгэлд 1.6-2.2%-ийн багахан

/Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

хувийг эзэлж байгаа нь эдгээр орлогын төрөл нийт төсвийн орлогын хэмжээнд шууд нөлөө үзүүлдэггүйг харуулж байна. Гэвч нөгөө талаас, хүү, торгуулийн орлого нь татварын бус орлогын бүтцэд 31 хүртэлх хувийг эзэлж байгаа нь татварын бус орлогын тогтвортой бүрэлдэхүүн гэж үзэх үндэслэлтэй байна. Иймд хүү, торгуулийн орлогын өсөлт, бууралтын аль аль нь татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд шууд нөлөөтэй байна. Тухайлбал:

- Хүү, торгуулийн орлого өсөх тохиолдолд нийтлэг татварын бус орлогын биелэлт богино хугацаанд нэмэгдэж, төсвийн санхүүжилтийн дарамтыг бууруулах боломжтой.
- Буурах тохиолдолд бусад орлогын эх үүсвэрээр нөхөх шаардлага үүсч, төлөвлөгөө тасалдах, хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлын санхүүжилт буурах, төсвийн сахилга бат алдагдах эрсдэлтэй байна.

Өөрөөр хэлбэл, хүү, торгуулийн орлогын биелэлт 10 хувиар буурахад татварын бус орлого 3 орчим хувиар шууд буурах магадлалтай байна.

Хүү, торгуулийн орлогын нийт орлогод эзлэх хувь бага боловч, татварын бус орлогын бүтцэд өндөр хувь эзэлж байна. Тиймээс хүү, торгуулийн орлогын өсөлт, бууралт нь татварын бус орлогын бусад эх үүсвэрт шууд нөлөө үзүүлэхийг илтгэж байна.

Эрх бүхий албан тушаалтны 2023-2024 онд ноогдуулсан торгуулиас 442.8 сая төгрөг, хүүгийн орлогоос 994.1 сая төгрөг нийт 1,436.9 сая төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Б.2. Торгуулийн орлогоос төсвийн эх үүсвэр болгон хуваарилах зардлыг 2023 онд 192.9 сая төгрөг, 2024 онд 312.3 сая төгрөгөөр тус тус дутуу хуваарилсан байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 353.4 сая төгрөг, 2024 онд 315.7 сая төгрөг хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №13

		/Сая төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	2023 он	2024 он
1	Төлөвлөсөн нийт торгуулийн орлого	1,291.2	1,505.2
2	Хуваарилах ёстой 40%	516.5	609.3
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан дүн	353.4	315.7
4	Зөрүү	163.1	293.6
5	Зөвшөөрөгдөх хэмжээнд илүү хуваарилсан дүн	(29.8)	(18.7)
6	Үүнээс дутуу хуваарилсан дүн	192.9	312.3

/Эх сурвалж: Хөвсгөл аймгийн 2023, 2024 оны төсөв баталсан тогтоол, санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Хүснэгтээс харахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 192.9 сая төгрөг, 2024 онд 312.3 сая төгрөгийг дутуу хуваарилсан байна. Энэ нь Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁹ дэх заалттай нийцэхгүй байна.

Торгуулийн орлогыг замын сангийн хөрөнгийн эх үүсвэр болгохоор хуульчилсан боловч уг орлогыг төсвийн нийт эх үүсвэрт нэгтгэн оруулж, бөөн дүнгээр хуваарилдаг тул торгуулийн орлогоос замын санд хэдэн төгрөгийг хуваарилсныг хянах боломжгүй байна.

Жил бүрийн төсвийн төсөлд хийсэн нийцлийн аудитаар төсвийн төслийн боловсруулалтад суурь судалгаа, тодорхой аргачлал дутагдалтай байгаа талаар дүгнэлтийг гаргасан. Энэхүү аудитаар торгуулийн орлогыг хууль тогтоомжид нийцүүлэн хуваарилсан эсэхийг хянаж үзэхэд хүү, торгуулийн орлогыг хуваарилах арга аргачлалгүй байна.

БҮЛЭГ 3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

В.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд хуваарилсан 669.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч үр дүнг тооцоогүй байна.

Хүү, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд аймгийн хэмжээнд 2023 онд 353.4 сая төгрөг, 2024 онд 315.7 сая төгрөгийг хуваарилан баталсан байна. Зардлыг ангилан харуулбал дараах байдалтай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал

Хүснэгт №-14

/Сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	2023 он	2024 он	Нийт
Аймгийн ИТХ-ын төсөвт				
1	Сумдын ИТХ	6.1	1.5	7.6
2	Аймаг орон нутгийн төсөвт байгууллага	63.1	56.6	119.7
3	Өмгөөллийн зардал	19.4	2.5	21.9
4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт	56.5	56.7	113.2
5	Тоног төхөөрөмж	16.5	26.8	43.3
6	Шатахууны зардал	16.7	18.2	34.9
	Дүн	177.9	162.6	340.5
7	Сумдын төсөвт	175.5	153.1	328.6
	Нийт дүн	353.4	315.7	669.1

Аймгийн ИТХ-ын төсөвт батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 2023, 2024 онуудад сумын ИТХ-д 7.6 сая төгрөг, бусад төрийн байгууллагад 119.7 сая төгрөгийг хуваарилан шилжүүлж, 213.3 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон тоног төхөөрөмжийн зардалд зарцуулсан байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын төсөвт батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлаас төсвийн байгууллагуудад 2023 онд 69.1 сая төгрөг, 2024 онд 58.1 сая төгрөгийг тус тус олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-15

/Сая төгрөгөөр/

№	Төсвийн байгууллага	2023 он	2024 он	Дүн
1	Цагдаагийн газар	50.8	45.6	96.4
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	1.4	5.0	6.4
3	Шүүхийн шинжилгээний хэлтэс	7.0	-	7.0
4	Прокурорын газар	3.0	2.0	-

⁹ "...зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ

5	Соёл урлагийн газар	0.9	-	5.0
6	Хилийн цэргийн 0257-р анги	-	2.0	0.9
7	Тагнуулын хэлтэс		2.0	2.0
8	Сумдын ИТХ, ЗДТГ	6.1	1.5	7.6
	Нийт дүн	69.1	58.1	127.2

Дээрх санхүүжилтийг тухайн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон бөгөөд зарцуулалтын эрхийг зохих журмын дагуу эрх нээлгэж зарцуулсан байна. Үүнд:

2023 оны зарцуулалт:

- Олон нийтийн цагдаагийн урамшуулалд 50.8 сая төгрөг,
- Цагдан хорих байрны теле камерын засварт 1.4 сая төгрөг
- Шүүхийн шинжилгээний багаж тоног төхөөрөмжийн зардалд 7.0 сая төгрөг
- Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх аяны зардалд 3.0 сая төгрөг
- Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх ажилд 0.9 сая төгрөг
- Шилдэг сумын урамшуулал 1.5 сая төгрөг
- Цагдаагийн купоны засварт 2.5 сая төгрөг
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн сургалтын зардал 1.1 сая төгрөг
- Цагдаагийн газрын албан хаагчдад тоног төхөөрөмж худалдан авах зардал 1.0 сая төгрөг.

2024 оны зарцуулалт:

- Олон нийтийн цагдаагийн урамшуулалд 45.6 сая төгрөг
- Зайны сургалтын тоног төхөөрөмж худалдан авах 5.0 сая төгрөг
- Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажилд 2.0 сая төгрөг
- Монгол цэргийн өдөр хууль сурталчлах арга хэмжээнд 2.0 сая төгрөг
- Нууцын зэрэглэлийн сургалт болон хяналтын зардалд 2.0 сая төгрөг
- Шилдэг сумын урамшуулал 1.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байна.

Хүү торгуулийн орлогын эх үүсвэрээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд иргэд олон нийтэд чиглэсэн дараах сургалт нөлөөллийн арга хэмжээнд зохион байгуулсан байна Үүнд:

- Өсвөр насны хүүхдүүд цагаа зөв боловсон өнгөрүүлэх сургалт 4.0 сая төгрөг,
- Өөрийгөө өөрчилж сургалт- 3.7 сая төгрөг
- Гэр бүл хүчирхийллийн эсрэг сургалт 3.0 сая төгрөг
- “Нэгдье” аяны сургалт 1.0 сая төгрөг
- Сумын цэргийн насныханд зориулсан сургалт 2.0 сая төгрөг
- Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сургалт 1.0 сая төгрөг
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт 3.1 сая төгрөг
- Хамтарсан багийн кессийн сургалт 6.2 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт 2.0 сая төгрөг
- Монгол цэргийн өдөр хууль сурталчлах сургалт 2.0 сая төгрөг
- Нууцын зэрэглэлийн сургалт 2.0 сая төгрөг
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт 11.7 сая төгрөг
- Архины хамааралтай иргэдэд зориулсан сургалт 3.7 сая төгрөг
- Увс аймагт алба хаах цэргийн алба хаагчдын сургалтад 4.1 сая төгрөг

Аймгийн хэргэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг иргэдэд хүргэх, сурталчлан таниулах арга хэмжээний хүрээнд хэвлэл, тараах материал, боршурын зардалд 2023 онд 30.3 сая төгрөг, 2024 онд 21.9 сая төгрөг нийт 52.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаар санхүүжүүлсэн сургалт нөлөөллийн үйл ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, тараах материалуудыг иргэд олон нийтэд хүргэж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Өмнөх бүлгүүдэд тайлбарласан хүү, торгуулийн орлогын хуваарилалт, зарцуулалтын үр дүнд нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг дараах байдлаар тодорхойллоо.

Хөвсгөл аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо болон зам тээврийн ослын статистик тоон үзүүлэлтийг 5 жилээр авч харьцуулалт хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №-17

Хэргийн ангилал	2020	2021	2022	2023	2024
Гэмт хэрэг, зөрчил	535	716	843	600	693
Зам тээврийн осол	153	127	158	129	140

/Эх сурвалж: 1212.mn/

Хүснэгтээс харахад 2020-2022 онд гэмт хэрэг, зөрчлийн тоо жил бүр өссөн бол 2023 онд 243 тохиолдлоор буюу 28.8 хувиар буурсан эерэг өөрчлөлт гарсан байна.

Гэвч 2024 онд дахин өссөн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд арцуулсан зардал тогтвортой үр нөлөө үзүүлээгүйг илтгэж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүнд:

- Тоног төхөөрөмжийн шинэчлэл, олон нийтийн цагдаагийн урамшуулалд 110.8 сая төгрөг зарцуулсан нь иргэдийн хяналт, оролцоо, аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн
- Иргэдэд чиглэсэн эрх зүйн мэдлэг олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 102.6 сая төгрөг зарцуулснаар иргэд, олон нийтийн хууль эрх зүйн ойлголтыг нэмэгдүүлсэн,
- Замын сангийн хөрөнгийн эх үүсвэрт торгуулийн орлого тодорхой хувийг бүрдүүлж байгаа учраас замын сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн 19 төсөл арга хэмжээний үр дүнд иргэдийн амьдрах таатай орчин бүрдсэнээр иргэдийн сэтгэл ханамжийн түвшин нэмэгдсэн байх зэрэг эерэг үр дагавартай байна.

Гэвч “Шилдэг сумын урамшуулал”, “Хууль сурталчлах өдөрлөг”, “Монгол цэргийн өдөр” зэрэг арга хэмжээнд зарцуулсан зардлууд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шууд үр нөлөө бүхий зардал биш тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын үр өгөөжийг бууруулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан зардал нь богино хугацаанд тодорхой эерэг нөлөө үзүүлсэн боловч зөрчлийн тоо тогтмол буураагүй нь зардлын хуваарилалт, зориулалт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Иймд хүү, торгуулийн орлогын эх үүсвэрийг оновчтой, зориулалтын дагуу хуваарилж, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, үнэлгээ хийснээр нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх боломжтой байна.

В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг эрх бүхий байгууллагуудын санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэн шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн байна.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд аймгийн ИТХ-ын төсөвт батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсөв, байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон 127.2 сая төгрөгийн зарцуулалтыг мэдээлж ажилласан байна.

Хүү торгуулийн орлогын зарцуулалтын талаарх дүн, тайланг нэгтгэж иргэд олон нийтэд хүргэсэн ажлын баримт материал, тайлан мэдээ байхгүй байна.

Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудын зүгээс хүү, торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд үнэлгээ өгсөн албан ёсны санал, шүүмжлэлт дүгнэлт, судалгаа мэдээллийн баримт нотолгоо байхгүй. Энэ нь иргэдийн оролцоо, хяналтын орон зай харьцангуй сул байгааг харуулж байна.

БҮЛЭГ 4

Хүү, торгуулийн орлогын нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг нэвтрүүлээгүй, ноогдуулсан торгуулийн хэрэгжилтэд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх чиг үүргийн байгууллагыг хуулиар тодорхойлоогүй байна

Улсын хэмжээнд зөрчил, торгууль, шийтгэлийн мэдээллийг нэгтгэн бүртгэх, байгууллага хооронд мэдээлэл солилцох, орлого бүрдүүлэлтийн хэрэгжилтийг хянах **нэгдсэн бүртгэл, хяналтын систем** бүрэн бий болоогүй байна. Байгууллага бүр өөрийн салбарын бүртгэлийн программ хангамжийг тус тусдаа ашигладаг, зарим газарт бүртгэлийн цахим систем огт ашигладаггүй зэрэг нь салбар тус бүрд хяналтын зарчим ижил тэгш бус, эрх бүхий албан тушаалтнуудын торгууль ноогдуулах үйл явц ялгаатай, нэгдсэн тогтолцоо бүрдээгүйг илтгэж байна.

- Улсын прокурорын ерөнхий газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/208 дугаар тушаал-ын дагуу “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн сан”-г 2022 оноос туршилтаар ашиглаж эхэлсэн боловч энэхүү систем нь одоогоор орон даяар бүрэн хэрэгжээгүй байна.
- Мөн Прокурорын байгууллага нь 2017 оноос үйл ажиллагааныхаа дотоод хэрэгцээнд зориулсан бүртгэлийн нэгдсэн системийг ашиглаж байгаа боловч энэ нь зөвхөн прокурорын хяналт, хэрэг бүртгэлд чиглэгдсэн, бусад хяналтын болон эрх бүхий байгууллагуудтай шууд мэдээлэл солилцох боломжгүй систем байна.
- Мэргэжлийн хяналтын газар татан буугдахаас өмнө 2016 оноос хойш <http://khyanal.gov.mn/> буюу “Шилэн хяналтын цахим систем” ашиглаж байсан бөгөөд энэхүү системийг хөгжүүлэхэд 2021 онд улсын төсвөөс 230.0 орчим сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Гэвч Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсанаар системийн үндсэн хэрэглэгч, зохион байгуулах бүтэц үгүй болж, салбарын хяналтыг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах үүрэгтэй байгууллага, албан тушаалтан тодорхойгүй болсон байна. Үүний улмаас Шилэн хяналтын цахим систем ашиглагдахаа больж, зөвхөн эрх бүхий зарим албан тушаалтан хяналтын төлөвлөгөө, зөрчлийн бүртгэлийг албан хэрэгцээнд дотооддоо хязгаарлагдмал байдлаар ашиглаж байгаа нь системийн хөгжүүлэлтэд улсын төсвөөс зарцуулсан 230.0 сая төгрөгийн зарцуулалт үр дүнгүй болсныг харуулж байна.

Г.1. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлээгүй, мэдээллийн сан бий болоогүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлд зааснаар зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээд торгуулийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлөх зохицуулалттай хэдий ч, аудитын явцад цуглуулсан мэдээллээс харахад эрх бүхий албан тушаалтнуудын шийтгэврийн мэдээлэл нь нэгдсэн бүртгэлд бүрэн нэгтгэгддэггүйгээс зарим төрлийн торгуулийг цахимаар төлөх нөхцөл хангагдаагүй байна.

Гэсэн ч замын хөдөлгөөний зөрчлийн торгуулийг төлөх боломжийг хангах зорилгоор **e-Mongolia, SmartCar, Гэрэгэ киоск**, банкны интернэт болон мобайл банкны аппликейшн зэрэг төлбөрийн цахим сувгууд өргөн ашиглагдаж байна. Замын цагдаагийн байгууллагаас ногдуулсан торгуулийн мэдээлэл тус бүрийг дахин давтагдашгүй дугаар, бар кодоор тэмдэглэж, төлөлтийн явцад хяналт тавих, торгуулийн биелэлтийг тооцох нөхцөл бүрдүүлж, цагдаагийн байгууллагын хувьд системийн хэрэгжилтийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж чадсан байна.

Харин Цагдаагийн байгууллагаас 2014 оноос хойш хэрэгжүүлсэн **камерын хяналтын систем**, бэлэн бус төлбөрийн систем зэрэг нь зөрчлийг илрүүлэх, төлөлтийг хянах үр дүнтэй арга болж, 2019 оны байдлаар зөрчлийн 25 орчим хувийг камерын хяналтаар илрүүлж, бэлэн бус торгуулийн эргэн төлөлтийг 60 хувьд хүргэж чадсан байна.

Системийн хяналтаас гадна хууль эрхзүйн орчинд дараах зохицуулалтууд орсон нь ноогдуулсан торгуулийг хугацаанд нь биелүүлэх нэг хөшүүрэг болсон байна. Тухайлбал: УИХ-аас 2023 оны

12 дугаар сарын 07-ний өдрийн “Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуульд шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэлийг баталсан, мөн ноогдуулсан торгуулийг удаа дараа төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах, төрийн байгууллагуудын холбогдох үйлчилгээгээр хангахгүй байх зэрэг зохицуулалтуудыг хийсэн нь Замын цагдаагийн тасгийн эрх бүхий албан хаагчдын ноогдуулсан торгуулийн орлого бүрдүүлэлтийн хувийг өсгөх гол хүчин зүйл болсон байна.

Зөрчил, торгуулийн мэдээллийн нэгдсэн цахим систем бий болоогүй, зөвхөн цагдаагийн байгууллагын хувьд зөрчил, төлөлтийн цахим системийг хөгжүүлж, үр дүнтэй ашиглаж байна.

Нэгдсэн систем бүрэн хөгжиж, шат дамжлагыг хялбаршуулан хэрэгжүүлснээр зөрчлийн хяналтын ил тод байдал, орлогын биелэлт, эрх бүхий албан тушаалтан болон иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх бодит үр өгөөж бий болно.

Г.2 Эрх бүхий байгууллагуудаас ноогдуулсан торгуулийн хэрэгжилтэд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх чиг үүргийн байгууллагыг хуулиар тодорхойлоогүй байна.

Аудитын нэгдсэн судалгаагаар аймгийн хэмжээнд 2023 онд 1,610.3 сая төгрөгийн, 2024 онд 1,249.9 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна. Үүнээс хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй торгуулийн мэдээллийг байгууллагаар нь ангилан харуулбал:

Хүснэгт №-18

/Сая төгрөгөөр/

Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	2023 он			2024 он		
	Ноогдуулсан	Үүнээс		Ноогдуулсан	Үүнээс	
		Төвлөрсөн	Дутуу		Төвлөрсөн	Дутуу
Хугацаа хэтэрсэн нийт торгуулийн дүн	1,547.4	1,335.5	211.9	1,207.4	976.0	230.9
Хөвсгөр аймгийн ХХҮГ	1.7	1.7	-	27.8	14.8	13
Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	3.1	3.1	-	9.1	6.1	3
Нийт	4.8	4.8	0	36.9	20.9	16
Татварын газар	246.0	226.7	19.3	185.4	113.5	71.9
Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар	1,230.5	1,044.7	185.8	911.2	774.0	137.2
Хөвсгөл аймгийн Байгаль орчны газар	30.1	29.3	0.8	27.9	27.6	0.3
Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	36.0	30.0	6.0	46.0	40.0	5.5
Нийт	1,542.6	1,330.7	211.9	1,170.5	955.1	214.9

/Эх сурвалж: “Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт” гүйцэтгэлийн аудитын нэгдсэн судалгаа/

Хүснэгтээс харахад дээрх байгууллагууд нь 2023 онд ноогдуулсан торгуулиас хугацаа хэтэрсэн 211.9 сая төгрөг, 2024 оноос 230.9 сая төгрөг нийт 442.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн торгуулийг бүрэн төлүүлээгүй байна. Энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1¹⁰, 7.5 дугаар зүйлийн 8¹¹ дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд ноогдуулсан торгуулийн биелэлтийг харгалзан үздэггүй нь эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэл, хариуцлагыг бууруулах эрсдэлийг дагуулж байна.

Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад санхүүгийн болон хууль зүйн түвшний хяналт хэрэгжүүлэхээр салбар тус бүрийн хуулиар тодорхойлсон байна.

Аймгийн санхүү төрийн сангийн хувьд: Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, санхүү төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба нь санхүүгийн гүйцэтгэлийг хянах чиг үүрэгтэй байна.

¹⁰ Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна”,

¹¹ хэсэгт “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана.”

Дээрх хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд нь орлого бүрдүүлэлтийг зөвхөн орж ирсэн орлогын гүйцэтгэлээр хянаж байгаа бөгөөд торгуулийн ногдуулалтын хэмжээ, хугацаа хэтрэлт, төлөлтийн явцад нэгдсэн хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, хяналт сул байна. Харин зарцуулалтын хувьд анхан шатны баримтыг үндэслэн хяналт хэрэгжүүлж байгаа ч зарцуулсан төсвийн үр дүнд тавих хяналт хангалтгүй байна гэж үзлээ.

Прокурорын хяналтын хувьд:

Тус байгууллагаас 2023, 2024 онд хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтны тавьсан торгуулийн үндэслэл болон гомдол маргаанд дараах хяналт хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байна. Үүнд:

Хүснэгт №-19

№	Хяналтын ангилал	2023 онд хэрэгжүүлсэн тоо	2024 онд хэрэгжүүлсэн
1	Хялбаршуулсан хэрэг шалгасан	1,671	781
2	Хүлээн авахаас татгалзсан гомдол	193	131
3	Зөрчлийн хэрэг нээсэн	950	1,393
4	Бүртгэлийн хэрэг нээсэн	33	83
6	Гомдол, мэдээллийн үлдэгдэл	23	25
Нийт хяналт шалгалт хийсэн тоо		2,870	2,413
Эцэслэн шийдвэрлэсэн хувь		99.9	97.6

Хүснэгтээс харахад 2023 онд нийт 2,871 хяналт хэрэгжүүлж, 99.9 хувьтай, 2024 онд 2,423 хяналт шалгалт хэрэгжүүлж, 97.6 хувьтай эцэслэн шийдвэрлэсэн байдлаас харахад хууль эрх зүйн хяналт хангалттай хэмжээнд хэрэгжиж байгааг илтгэж байна.

Шүүхийн хяналтын талаар:

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2023, 2024 онуудад шүүхээс хүчингүй болгосон торгуулийн мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-20

/Сая төгрөгөөр/

№	Торгууль ногдуулсан байгууллагын нэр	2023		2024	
		Хүчингүй болгосон торгуулийн тоо	Мөнгөн дүн	Хүчингүй болгосон торгуулийн тоо	Мөнгөн дүн
1	Цагдаагийн газар	23	1.4	733	10.9
2	Байгаль орчны газар			39	25.5
Нийт		23	1.4	772	36.4

Хүснэгтээс харахад эрх бүхий албан тушаалтны тавьсан торгуулиас 2023 онд 1.4 сая төгрөгийн 23 торгууль, 2024 онд 36.4 сая төгрөгийн 772 торгуулийг хууль эрх зүйн үндэслэлгүй гэж шүүхээс хүчингүй болгож, шийдвэрлэсэн байна.

Дээрх газрууд нь Шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон нийт 37.8 сая төгрөгийн 795 торгуулийн мэдээллийг системээс хасах, төлөгдсөн торгуулийг хэрхэн шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулаагүй байна. Энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15¹² дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Торгууль, шийтгэл ноогдуулах эрх бүхий байгууллагын хувьд:

Засгийн газрын 2021 оны 134 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ыг боловсруулсан байна. Тус журамд заасны дагуу шийтгэлийн хуудас буюу үнэт цаасыг аймгийн санхүү төрийн сан хариуцан бүртгэлээр олгож, тооцоо бодож, тайлагнах үүрэгтэй байна.

Эрх бүхий байгууллага нь шийтгэлийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтныг томилж, түүнийг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч хяналт тавих чиг үүрэгтэй байна.

¹² Эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг гаргахдаа зөрчил шалгах ажиллагааны журмын дагуу хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн талаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”

2022-2024 онд санхүү, төрийн сангийн хэлтсээс эрх бүхий албан тушаалтанд олгосон шийтгэлийн хуудасны мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-21

№	Сангийн яамнаас хүлээн авсан	Эрх бүхий албан тушаалтанд олгосон	Үлдэгдэл
1	3,310	3,062	248

Хүснэгтэд үзүүлснээр эрх бүхий албан тушаалтанд олгосон 3062 шийтгэлийн хуудас /үнэт цаас/-аас дараах байгууллагуудад олгосон 115 шийтгэлийн хуудасны бүртгэл, хадгалалт, хамгаалалт,

зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, эрх бүхий албан тушаалтантай сар бүр тооцоо хийгээгүй, аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст шийтгэлийн хуудасны тооцоог бүрэн хүргүүлээгүй байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Стандарт хэмжилзүйн газар
- Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар
- Улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа

Энэ нь Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2¹³, 2.12¹⁴, 2.13¹⁵ дахь заалтуудтай д тус тус нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс нь шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягтыг эрх бүхий байгууллагад олгох, тайлан мэдээг хүлээн авч, тооцоо нийлэх үйл ажиллагаанд бүрэн хяналт тавиагүй, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог бэлтгэж хүргүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан *"Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам"*-ын 2 дугаар зүйлийн 2.14¹⁶-т заасанд нийцэхгүй байсан тул зөвлөмж хүргүүлж шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан *"Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"*-ын 2.3¹⁷-т заасны дагуу тухайн байгууллагууд үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын хамрах хугацаанд Иргэн, ТББ, ОУБ-аас хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтийг зөвхөн орлогын гүйцэтгэлээр хянаж байгаа нь ногдуулсан торгуулийн биелэлт, хугацаа хэтрэлтэд тавих эрх бүхий албан тушаалтны хяналт орхигдсон, нэгдсэн цахим хяналтын систем дутагдалтай байгааг харуулж байна.

Аудитаар нийт 2,026.7 сая төгрөгийн 11 зөрчил илэрч, 9.6 сая төгрөгийн 1 зөрчлийг аудитын хугацаанд төлүүлж, 2,017.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад хугацаатай 10 зөвлөмж хүргүүлж шийдвэрлэсэн.

¹³ "Шийтгэлийн хуудсыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн хэвлүүлж, аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгжид албан хүсэлтийн дагуу бүртгэлээр олгох бөгөөд түүнийг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт, зарцуулалтад тухайн эрх бүхий байгууллагын дарга, нягтлан бодогч хяналт тавина",

¹⁴ "Эрх бүхий албан тушаалтан шийтгэлийн хуудасны тооцоог сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон шийтгэлийн хуудсыг олгох, тайлан, тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтантай хийж, тухайн байгууллагын ахлах нягтлан бодогч хяналт тавьж, улирал бүр удирдлагад танилцуулж баталгаажуулна."

¹⁵ "Эрх бүхий байгууллага нь жил, хагас жил тутам аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгж эсхүл холбогдох дээд шатны байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог хүргүүлж баталгаажуулна."

¹⁶ "Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгж, эрх бүхий байгууллага нь жил бүр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог хийнэ

¹⁷ "Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино."

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого төвлөрүүлэгч байгууллагуудын санал, төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл, тооцоо судалгаа, эх үүсвэрийг бодитой тодорхойлоогүй, хүүгийн орлогод дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүд төлөх төлбөрийг тусгасан, ЖДҮ-ийг дэмжих сангийн харилцах дансны үлдэгдэлд бодогдох хүүг төлөвлөөгүй, зэргээс харахад орлогын эх үүсвэрийг үнэн зөв тодорхойлоогүй байна.
2. Эрх бүхий албан тушаалтан ноогдуулсан торгуулийн хэрэгжилтэд анхаарч ажиллаагүйгээс 2023-2024 онд 442.8 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан зардал нь богино хугацаанд тодорхой эерэг нөлөө үзүүлсэн боловч зөрчлийн тоо тогтмол буураагүй нь зардлын хуваарилалт, зориулалт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Иймд хүү, торгуулийн орлогын эх үүсвэрийг оновчтой, зориулалтын дагуу хуваарилж, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, үнэлгээ хийснээр нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх боломжтой байна.
4. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг эрх бүхий байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэн шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн боловч иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудын зүгээс ил тод байдалд үнэлгээ өгсөн албан ёсны санал, шүүмжлэлт дүгнэлт, судалгаа мэдээллийн баримт нотолгоо байхгүй нь иргэдийн оролцоо харьцангуй сул байгааг харуулж байна.
5. Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтийг зөвхөн орлогын гүйцэтгэлээр хянаж байгаа нь ногдуулсан торгуулийн биелэлт, хугацаа хэтрэлтэд тавих эрх бүхий албан тушаалтны хяналт орхигдсон, нэгдсэн цахим хяналтын систем дутагдалтай байгааг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журамд заасан зориулалт, хувь хэмжээнд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах
2. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлтөд хяналт тавьж ажиллах

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

3. Хүү, торгуулийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, нэр төрөл тус бүрээр нь гүйцэтгэлийг жигд ханган биелүүлэх, үнэн зөв тайлагнаж ажиллах
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцож, хуваарилах

Санхүү, төрийн сангийн хэлтэст:

5. Шийтгэлийн хуудас /Үнэт цаас/-ыг хүлээн авах, бүртгэх, олгох, тайлагнах эрх бүхий албан тушаалтныг томилох
6. Торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудын орлогын биелэлтэд хяналт хэрэгжүүлэхэд ойлгомжтой байхаар дансны хуваарилалтыг хийх
7. Улсын төсөвт төвлөрүүлж байгаа торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг хууль журмын дагуу зохион байгуулах
8. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүгийн төлбөрийг хүүгийн орлогоор төлөвлөхгүй байх
9. Хүү, торгуулийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв тодорхойлж, бодит тооцоо, судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөх

Торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад: /Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар, Байгаль орчны газар, Татварын газар, Хөвсгөл аймгийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Стандарт хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн газар, Санхүүгийн хяналт дотоод аудитын газар/

10. Ноогдуулсан торгуулийг хугацаанд нь бүрэн барагдуулах арга хэмжээг авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
11. Шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон торгуулийн мэдээллийг мэдээллийн системээс хасалт хийж, төлбөрийг буцаан олгох
12. Шийтгэлийн хуудас /үнэт цаас/-ны бүртгэл, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлж, зарцуулалтыг санхүү, төрийн сангийн хэлтэст батлагдсан маягтын дагуу тайлагнаж байх

Зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн		Өгсөн албан шаардлага		Тавьсан акт		Зөвлөмж	
	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Торгуулийн орлогыг суурь судалгаа, өмнөх оны гүйцэтгэл, байгууллагын саналд үндэслэн төлөвлөөгүй						1	
2	Дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүгийн төлбөрийг орон нутгийн төсөвт хүүгийн орлогоор тооцож төлөвлөсөн.	994.1					1	994.1
3	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд нь торгуулийн орлогыг улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн	37.2					1	37.2
4	Торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудын тавьсан торгууль нь хүү, торгуулийн орлого төвлөрүүлдэг 3 дансанд холилдож орсон, торгуулийн орлогын гүйцэтгэлийг байгууллага бүрээр гаргах боломж, хяналт хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй						1	0.0
5	Орон нутгийн төсвийн төслийг нэгтгэн боловсруулахдаа торгуулийн орлогын эх үүсвэрээр санхүүжүүлэх зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас бусад зардалд тооцон төлөвлөж хуваарилаагүй						1	
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 192.9 сая төгрөг, 2024 онд 312.3 сая төгрөг нийт 505.2 сая төгрөгийг дутуу хуваарилсан.	505.2					1	505.2
7	2023 онд ноогдуулсан торгуулиас хугацаа хэтэрсэн 211.9 сая төгрөг, 2024 оноос 230.9 сая төгрөг нийт 442.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн торгуулийг бүрэн төлүүлээгүй байна.	442.8					1	442.8
8	Шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон торгуулийн мэдээллийг системээс хасах, төлөгдсөн торгуулийг хэрхэн шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулаагүй байна	37.8					1	37.8
9	Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягтыг эрх бүхий байгууллагад олгох, тайлан мэдээг хүлээн авч, тооцоо нийлэх үйл ажиллагаанд бүрэн хяналт тавиагүй, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог бэлтгэж хүргүүлээгүй байна.						1	0,0
10	Шийтгэлийн хуудас /үнэт цаас/-ны бүртгэл, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлээгүй, эрх бүхий	-					1	0.0

албан тушаалтантай сар бүр тооцоо хийгээгүй, аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст ирүүлсэн зарцуулалтын тайлан нь маягтын дагуу биш, шаардлага хангаагүй.							
Нийт	2,017.1	-	-	-	-	10	2,017.1

Хавсралт №1

Эрх бүхий албан тушаалтны судалгаа

№	Торгууль ногдуулах эрх бүхий, байгууллагын нэр	Улсын байцаагчийн тоо
1	Авто тээврийн төв	1
2	Аймгийн засаг даргын тамгын газар	6
3	Аймгийн засаг даргын тамгын газар /Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч/	1
4	Байгаль орчны газар	21
5	Мал эмнэлгийн газар	23
6	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	3
7	Монгол банк	2
8	Эрүүл мэндийн газар	7
9	Онцгой байдлын газар	5
10	Татварын газар	36
11	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	2
12	Хөвсгөл аймаг дахь Тагнуулын газар	1
13	Стандарт хэмжил зүйн хэлтэс	3
14	Улсын бүртгэлийн хэлтэс	1
15	Ханх дахь гаалийн хороо	1
16	Санхүү, хяналт аудитын алба	4
17	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	3
18	Хүнс хөдөө аж ахуйн газар	4
19	Цагдаагийн газар	78
20	Нийгмийн даатгалын газар	19
21	Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	8
22	Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	12
23	Статистикийн хэлтэс	1
24	Хилийн цэргийн 0257 дугаар анги	24
25	Далайн захиргаа	1
26	Гадаадын иргэн харьяатын газрын хойд бүс дэх газрын хөвсгөл аймаг дахь хэлтэс	2
27	Дэлгэрмөрөн-шишхэд голын сав газрын захиргаа	1
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	3
29	Хөвсгөл аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	1
30	Боловсрол шинжлэх ухааны газар	1
Нийт		275

Хавсралт №2

Торгуулийн орлогын тайлагналын тулгалт

№	Сумын нэр	Данс	2023 он			2024 он		
			Нийт дансны хуулгаар орлого	Тайлангаарх торгуулийн орлого	Зөрүү	Нийт дансны хуулгаар орлого	Тайлангаарх торгуулийн орлого	Зөрүү
1	Аймаг	1700	620.8	635.5	(14.8)	968.9	741.3	227.6
2	Алаг-Эрдэнэ	1701	18.8	18.8	-	34.4	34.1	0.3
3	Арбулаг	1702	8.6	8.6	-	5.7	5.7	-
4	Баянзүрх	1703	7.7	7.7	-	5.8	5.8	-
5	Бүрэнтогтох	1704	8.0	8.0	-	4.2	5.9	(1.7)
6	Галт	1705	2.3	2.3	-	2.2	2.2	-
7	Жаргалант	1706	7.2	7.2	-	4.5	4.3	0.1
8	Их-Уул	1707	23.5	23.5	0.0	24.4	24.0	0.4
9	Рашаант	1708	11.7	11.3	0.4	3.2	3.2	-
10	Рэнчинлхүмбэ	1709	13.2	11.0	2.2	5.1	5.1	-
11	Тариалан	1710	49.9	49.9	-	34.9	34.9	0.0
12	Тосонцэнгэл	1711	25.5	24.1	1.5	35.3	33.5	1.8
13	Төмөрбулаг	1712	5.6	5.6	-	8.1	8.1	-
14	Түнэл	1713	7.3	7.3	-	8.2	8.2	-
15	Улаан-Уул	1714	11.8	11.8	-	7.5	7.5	-
16	Ханх	1715	2.2	2.2	-	1.9	1.9	-
17	Цагаан-Уул	1716	7.8	7.8	-	7.5	7.5	-
18	Цагаан-Үүр	1717	4.5	4.5	-	6.7	6.7	-
19	Цэцэрлэг	1718	6.2	6.2	-	4.4	4.4	-
20	Чандмань-Өндөр	1719	5.6	5.5	0.1	4.3	4.3	-
21	Шинэ-Идэр	1720	11.1	10.2	0.9	5.3	5.3	-
22	Хатгал	1721	32.8	32.3	0.5	40.5	39.0	1.5
23	Мөрөн	1722	552.1	552.1	-	519.0	736.4	(217.5)
24	Эрдэнэбулган	1723	15.9	14.2	1.7	14.7	14.6	0.1
25	Цагааннуур	1724	14.2	13.9	0.3	2.8	2.8	-
Нийт дүн			1,474.0	1,481.3	(7.3)	1,759.4	1,746.6	12.7